

Танилцуулгыг уншиж ,бүтэц
дарааллыг ойлгох

Хичээлийн зорилго

- ▶ Өмнө үзсэн хичээлээ сэргээн санах
- ▶ Эхийн утгын бүтэц, дарааллыг ойлгох

Үйл ажиллагаа1.

Өмнөх хичээлээ сэргээн саная

“Танилцуулга” гэдэг үгийн тайлбарыг Монгол хэлний тайлбар тольд:

- ▶ Бусдад танил болгох үүднээс тусгайлан үйлдсэн сурталчилгааны хэвлэмэл бүтээгдэхүүн
- ▶ Ямар нэг ажил хэргийн байдлыг мэдүүлэх зорилго бүхий бичиг баримт хэмээн тайлбарлажээ.

Хүснэгтийг хараад танилцуулга гэж юуг хэлэх вэ? Тодорхойлон бичье.

№	Танилцуулга		
	Төрөл	байгууллага , хамт олон, хувь хүний өнгөрсөн, одоо, ирээдүйн зорилго, зорилт, үйл ажиллагааны	ном, зохиол, уран бүтээл, бараа, бүтээгдэхүүн, аливаа шинэ нээлт, технологийн
1	Юуны тухай	шинж чанар, онцлог, давуу талыг	
2	Зорилго	бусдад таниулах, мэдээлэх, сурталчлах	
3	Ач холбогдол	танин мэдүүлэх	
4	Нөлөөлөх байдал	уншигч, сонсогчдыг ятгах, үнэмшүүлэх	
5	Шаардлага	товч, оновчтой, ойлгомжтой, тодорхой, албан бичгийн найруулгын шинжтэй	

Танилцуулга

Танилцуулга гэдэг нь аливаа байгууллага, хамт олон, хувь хүн-ний өнгөрсөн, одоо, ирээдүйн зорилго, зорилт, үйл ажиллагааны онцлог болон ном зохиол, уран бүтээл, бараа бүтээгдэхүүний шинж чанарыг бусдад таниулах, мэдээлэх, сурталчлах зорилготой.

Танилцуулгын онцлог:

- ▶ Албан бичгийн төрөл зүйл
- ▶ Сурталчилгааны шинжтэй
- ▶ Танин мэдүүлэх ач холбогдолтой
- ▶ Уншигч сонсогчийг ятган үнэмшүүлэхийг чухалчилдаг

Тавигдах шаардлага:

- ▶ Товч оновчтой
- ▶ Ойлгомжтой
- ▶ Тодорхой байх

Үйл ажиллагаа 2

Өмнө уншсан 2 танилцуулгын онцлогийг харьцуулж харъя

№	Асуулт	Монгол зурагт ном	Цор ганц олдвор
1	Эхлэлд уг юмын тухай товч мэдээлэл байна уу?	+	+
2.	Товч мэдээлэл нь юуны танилцуулга болохыг илэрхийлж байна уу?	+	+
3.	А. Мэдээлэх зорилготой юу?	+	+
	Б.Танилцуулах ач холбогдолтой юу?	+	+
	В.Тоо баримттай юу?	+	+
	Г.Өгүүлбэрүүд нь цагийн дараалалтай юу?	-	-
	Д. Тэмдэг нэр ашигласан уу?	-	-
	Е. Уран, дүрслэл, хэлц үг ашигласан уу?	-	-
	Ё.Ямар нэгэн шинэ мэдээ, мэдээлэл байна уу?	+	+
4.	А.Төгсгөл хэсэгт уншигчдыг уриалсан агуулга байна уу?	+	+
	Б.Сурталчилсан үг, өгүүлбэр байна уу?	+	+
5.	Товч тодорхой, ойлгомжтой байж чадсан уу?	+	+

Аяллын танилцуулга

Аялал эхлэх: 2015 03.14 - 2015-9.30

Аяллын хугацаа: хоёр өдөр,хоёр шөнө

Эрхэм таныг эх орныхоо байгалийн үзэсгэлэнт газраар аялангаа түүх соёлынхоо өвтэй танилцах боломж бид олгож байна. Та манай аяллын танилцуулгыг уншаад тодорхой мэдээлэл авна гэдэгт итгэлтэй байна. Ийнхүү таныг аялахыг урьж буй газар нутаг бол Дорноговь аймгийн Сайншанд хотоос урагш 38 км-т орших Хамарын хийд бөгөөд нь ноён хутагт Данзанравжаа 1821онд байгуулж, аж төрж, уран бүтээлээ туурвиж байсан дурсгалт газрын нэг юм. Энэ хийд нь Зүүн хүрээ, Баруун хүрээ, Цохон, Дүйнхэрийн гэсэн 4 хэсэгтэй, төвд, монгол хийцийн сүм дугануудтай. Зүүн хүрээнд нь ноён хутагт голлон суудаг байсан ба энд Лаврин сүм, Авга дацан, хүүхдийн дацан сургууль, номын сангаас гадна Хамбын, Лам нарын, Шүтээний, Номчийн аймгуудтай байсан. Хийдэд ноён хутагтын “Саран хөхөөний намтар” жүжгийг жил бүр найруулан тавьдаг байжээ. Энэ дацан нь гурав давхар. Сүм хэлбэрийн байшинтай, гучин таван жангийн хэмжээтэй уг театрыг салхины урсгал тааруулж барьсан учраас үзэгчдэд жүжгийн яриа, хөгжмийн аялгуу хүрэхэд хялбар байжээ.

Унших эх – Үргэлжлэл

Хамрын хийдийн орчимд тарнийн ёсны жарз бясалгал хийдэг арваад агуй, нутгийн ардууд хутагтын адисласан ус хэмээн нэрлэдэг ноён хутагтын гаргуулсан худаг бий. Эл худгийн усыг тэрээр ходоод, элэг, дотор эрхтний гэмийг арилгахад тустай хэмээн шүтдэг. 1930 онд 13 дацан, 4 аймаг, 22 дуган, 2 суварга, 11 сүмтэй байсан Хамрын хийд нь сүм хийдийг галдан шатаасан 1937-1938 оны үед туйр болтлоо сүйджээ. 1990–ээд оноос Лаврин, Санагтэгчилэн зэрэг сүмүүдийг сэргээн босгож шашны хурал номын үйл ажиллагааг сэргээж, хийдийн туйрыг 1994 онд аймгийн хамгаалалтад авчээ.

Бидний аялах түүх соёлын дурсгалт газрууд

- Мөөм овоо
- Энхийн хонх
- Шамбалын орон
- Хилэнцийг арилгах Алтан хаалга
- Бирдийн ходоод
- Сэржим өргөх талбай
- Суварга “Алтан гавал” овоо
- Бясалгалын агуй
- Ноён хутагтын сэнтий
- Хүслийн уул зэргийг та нэг дор үзэх боломжийг бид олгож байна.

Таныг бид урьж байна. Үүргэвчээ үүрээд аялалдаа гараарай.

Үгийн утгын тайлбар

Хийд – Буддын шашны лам нарын хуран суух сүм орон

Дүйнхэр - Цагийн хүрд гэсэн утгатай буддын шашны бурхны нэр

Лаврин – Хутагт хувилгаан лам нарын суух орон байшин

Авга дацан – Өвөр Монголын Авга хошуунаас ирсэн лам нарын сурах шашны сургууль

Номчийн аймаг – Хамарын хийдийн лам нарын суух хорооны нэг

Жан – Уламжлалт хэмжээсийн нэр. Арван тохойтой тэнцэнэ.

Тарнийн ёс – Буддын шашны тарни бясалган гэгээрлийг олох арга

Жарз – Тарнийн ёсны лам нарын заавал хийх ёстой олон хоногийн, тэвчээр шаардах зан үйл

Адислах – Буддын шашны лам нарын өршөөл соёрхол хүртээх ёс

Шамбалын орон – Буддын шашны номонд гарах гэгээрэгчдийн суух нэгэн орны нэр

Хилэнц – Нүгэл, буруу муу үйл

Бирд – Бурхны номд ертөнцийн зургаан зүйл амьтны нэг.

Сэржим- Алтан дусал гэсэн утгатай төвд үг. Архи сархдын дээжийг номын хүчээр рашаан болгон бурхан тэнгэр, газар усны эздийг тахих зан үйл

Суварга – Буддын шашны тахил мөргөлийн шүтээн

Бясалгал – Эрдэмд нэвтрэхийн тулд маш гүн бодож эргэцүүлэх

Сэнтий-Хутагт хувилгаадын суух арслангийн дүрсээр чимэглэсэн арслант ширээ

“Аяллын танилцуулга” эхийн хэсгүүд хоорондоо хэрхэн холбогдсоныг харъя

Эхлэл хэсэгт юуны тухай байна вэ?

Эхлэл хэсэгт аяллын зорилго, давуу талыг товч дурдсан.

Гол хэсэгт юуг өгүүлсэн байна вэ? Эхлэл хэсэгтэй яаж холбогдсон байна вэ?

Эхлэлд дурдсан аяллын давуу тал, зорилгыг дэлгэрүүлэн тоочиж өгүүлсэн ба эхний цогцолбортой “ийнхүү” гэсэн заах төлөөний үгээр холбогдсон .

Төгсгөл хэсэгт юуны тухай байна вэ? Эхлэл, гол хэсэгтэй яаж холбогдсон бэ?

Дээр дурдсан аялалд урьсан ба “Нэг дор үзэх боломжийг бид олгож байна.” гэсэн эхний цогцолборын өгүүлбэрийг давтаж, 2 цогцолбортой холбожээ.

Асуултын дагуу “Аяллын танилцуулга”-д шинжилгээ хийж үзье

№	Асуулт	Тийм	Үгүй	Тайлбар
1	Эхийн хэсгүүд холбоотой юу?	+		Эхлэл, гол, төгсгөл хэсгүүд холбоотой байсан.
2	Эхийн гол санаа өмнө уншсан танилцуулгаас өөр байна уу?	+		Аялах газрын тухай таниулан мэдээлсэн сурталчилсан.
3	Танилцуулгын зорилго тодорхой юу?	+		маш тодорхой.
4	Тоо баримттай юу?	+		Тооны нэр их хэрэглэсэн
5	Чухалчилсан санаа, шинэ мэдээлэл өгч чадсан уу?	+		Шинэ мэдээлэл өгсөн.
6	Уран дүрслэл, хэлц үг ашигласан уу?		+	Дүрслэх ур маяг ашиглаагүй. Үгийг шууд утгаар ашигласан.Бодит баримтад тулгуурласан.
7	Тэмдэг нэр хэрэглэсэн үү?		+	Тэмдэг нэр ашиглаагүй
8	Өгүүлбэрүүд нь цагийн дараалалтай юу?		+	Тоочсон , зэрэгцсэн өгүүлбэрүүд голлосон
9	Уншигч, сонсогчдод нөлөөлөх, уриалах, бахархах сэтгэгдэл төрүүлэх үг, өгүүлбэр байна уу?	+		Сонирхлыг татсан, уриалсан, зөвлөсөн

Дүгнэлт

Танилцуулгын бүтэц :

Эхлэл хэсэг	Танилцуулах зүйлийн тухай товч бичнэ.
Гол хэсэг	<ul style="list-style-type: none">• Эхлэл ,гол, төгсгөл хэсгүүд нь холбоотой.• Тоо баримт ашигладаг учраас тооны нэрийг хэрэглэдэг.• Тоочсон , зэрэгцсэн өгүүлбэрийн найруулга голлосон байдаг.• Үгийг шууд утгаар хэрэглэдэг• Бодит баримтад тулгуурладаг.
Төгсгөл хэсэг	<ul style="list-style-type: none">• Танилцуулж байгаа зүйлийн үр өгөөж, ач тусыг дүгнэж хэлдэг.

Анхаарал тавьсанд баярлалаа.